ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 09 дүгээр сарын 23 өдөр Дугаар 85 Хэрлэн сум

LXXXV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 85 дугаар хуралдаан 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 15:00 цагт танхимаар 73,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Үхрийн арьс товруутах өвчний нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

Мал эмнэлгийн газар

2.Малын отор нүүдлийг хязгаарлах эсэх талаар хэлэлцэх,

Мал эмнэлгийн газар
Хүнс, хөдөө аж ахуйн газар

3.Цэрэг татлагын ажлыг зохион байгуулах талаар санал танилцуулах,

АЗДТГ-ын Цэргийн штаб

4.Газар өмчлөхтэй холбоотой асуудлын талаар хэлэлцэх,

Хэрлэн сумын Засаг даргын Тамгын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.АЗДТГ-ын Цэргийн штабын дарга, Онцгой комиссын гишүүн, дэд хурандаа О.Ганзориг,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, Цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн захирал, Онцгой комиссын гишүүн Д.Должин,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.1.Ээлжит цэрэг татлагын ажлыг 2021 оны 10 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд Биеийн тамир, спорт хорооны газрын спорт зааланд халдвар хамгааллын дэглэмийг баримтлан иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүй байдлаар зохион байгуулах,

1.2. Ээлжит цэрэг татлагад хамрагдах иргэдээс ПГУ шинжилгээ, түргэвчилсэн шинжилгээ авах ажлыг шуурхай зохион байгуулах,

/ / М.Бадамсүрэн
/ / х/ч Б.Цогтбаяр

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий-д:

1.3.Ээлжит цэрэг татлагын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллах,

Хоёр.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
Цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ж.Алимаа,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

2.1.Баянтүмэн, Хөлөнбуйр сумын гүүр, Догнигор, Ялалт, Модон гүүрүүдэд хяналтын цэг байгуулж халдваргүйтгэл хийх, малын гарал үүслийн бичиг хяналт тавьж ажиллах,

2.2.Баянтүмэн, Хөлөнбуйр сумын гүүр, Догнигор, Ялалт, Модон гүүрүүдэд хяналтын цэг ажиллахад шаардагдах зардлыг тооцож аймгийн Засаг даргын зөвлөлийн дараагийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

2.3.Халхгол, Баяндун, Сэргэлэн, Матад, Цагаан-Овоо, Булган, Баян-Уул, Хөлөнбуйр, Хэрлэн сумдын нутаг дэвсгэрт үхрийн арьс товруутах өвчнөөр өвчилсөн, клиник шинж тэмдэгтэй үхрийг устгах ажлыг зохион байгуулах,

2.4.Үхрийн арьс товруутах өвчний тархалт өндөр байгаа Чулуунхороот, Гурванзагал, Чойбалсан, Дашбалбар, Баянтүмэн сумдад 2021 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс эхлэн үхрийг амьдаар 28 хоногийн хугацаанд, үхрийн махыг 14 хоногийн хугацаанд худалдаалах, шилжилт хөдөлгөөн хийхийг хориглох,

2.5.Эрүүл мэнд, боловсрол, уул уурхайн аж ахуйн нэгжүүдэд өмнө нь гэрээ байгуулан нийлүүлж байсан үхрийн махны худалдааг өвчлөл гараагүй сум, өрхөөс нийлүүлэх талаар хяналт тавьж ажиллах,

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа-д:

2.6.Дорнод аймгийн нутаг дэвсгэрт нутаглаж буй бухнуудыг үхрийн арьс товруутах өвчний шинж тэмдэг илрүүлэх үзлэгт хамруулах,

2.7.Дорнод аймгийн нутаг дэвсгэрт малын отор нүүдлийн орж ирэх хөдөлгөөнийг хориглох, хяналт тавьж ажиллах,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа-д:

2.8.Дорнод аймгийн нутаг дэвсгэрт нутаглаж буй бухнуудыг үхрийн арьс товруутах өвчний шинж тэмдэг илрүүлэх үзлэгт хамруулах ажилд хяналт тавьж ажиллах,

/ М.Бадамсүрэн
/ /х/ч Б.Цогтбаяр

Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа,
Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн,
Цагдаагийн хурандаа Т.Ганзориг,
Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

2.9.Дорнод аймгийн Хөлөнбуйр сумаас бусад сумдын нутаг дэвсгэрээс өөр аймаг, нийслэл рүү хонь, ямааг амьдаар болон махаар тээвэрлэхэд холбогдох хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллах,

Гурав.Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-т:

3.1.Хэрлэн сумын хэмжээнд 2021 онд иргэдэд газар өмчлүүлэх тухай өргөдөл хүлээн авах ажлыг зохион байгуулахад халдвар хамгааллын дэглэм мөрдүүлэх, иргэдийн бөөгнөрөл үүсгэхгүй байхад хяналт тавьж ажиллах,

Дөрөв.Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий,
Боловсрол, соёл урлагийн газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа,
Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Э.Жавхлан,
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын дарга нарт:

4.1.Олон нийтийн эзэмшлийн гудамж талбайд амралтын өдрүүдээр төрийн байгууллагын албан хаагч нар хуваарийн дагуу коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах талаар хөдөлгөөнт зарлан мэдээллийн тээврийн хэрэгслээр ухуулга, сурталчилгааны ажлыг зохион байгуулах,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-т:

4.2.Олон нийтийн цахим сүлжээгээр коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах талаар уриалга, ухуулга сурталчилгааны ажлыг зохион байгуулах,

АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Э.Эрдэнэбилэг,
Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,
Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга,
Онцгой комиссын гишүүн Э.Жавхлан,

/ / М.Бадамсүрэн

/ / х/ч Б.Цогтбаяр

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

4.3.Дорнод аймгийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч нартай танхим болон цахимаар коронавируст халдварын одоогийн нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар уулзалт зохион байгуулж санал авч аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын
гишүүн Ж.Алимаа,
Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

4.4.Баарны үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн удирдлагуудтай коронавируст халдварын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцож аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

Аймгийн Онцгой комиссын нийт гишүүдэд:

4.5.Халдварт өвчин судлалын үндэсний төвөөс орон нутагт зохион байгуулж буй сургалтад идэвхитэй хамрагдаж оролцохыг тус тус үүрэг болгов.

ДАРГА М.БАДАМСҮРЭН